

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН

**ГАЛЫН ДОХИОЛЛЫН СИСТЕМ ШИНЭЧЛЭХ /ИНЕГ-ЫН БАЙР/ АЖЛЫГ
ГҮЙЦЭТГЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер
шалгаруулалт /
гэрээний нэр:**

Галын дохиоллын систем шинэчлэх /ИНЕГ-ын байр/ ажлыг
гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер
ИНЕГ/УЗ/ТББ/Б-46/20

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.06.09

Иргэний нисэхийн ерөнхий газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Галын дохиоллын систем шинэчлэх /ИНЕГ-ын байр/** ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер ИНЕГ/УЗ/ТББ/Б-46/20 дугаартай ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 06-р сарын 16-ны 10.00 цаг**-аас өмнө **Засгийн газрын худалдан авах цахим систем /www.tender.gov.mn/** цахим хуудсанд цахимаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 06-р сарын 16-ны өдрийн 10.30 цагт** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар болон www.tender.gov.mn цахим хуудаснаас авч болно.

**Улаанбаатар хот. Буянт-Ухаа. Иргэний нисэхийн ерөнхий газар.
ХААТасаг. 108 тоот өрөө.
Утас:71282127**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо /2019 он/ 2. Туршлагын мэдээлэл /сүүлийн 1 жилийн ажил тус бүрээр гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт/ 3. Маягтын дагуу үнийн санал ирүүлэх. 4. Тухайн компанийг төлөөлөх эрх бүхий этгээдийг албан ёсоор томилсон байх. 5. Ажил гүйцэтгэх хуваарь ирүүлэх. 6. Татвар, нийгмийн даатгал, харилцагч банк, бусад хуулийн этгээдээс лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлэх. 7. Гал унтраах болон галын аюулгүйн дохиоллын системийн угсралт, суурилуулалтын тусгай зөвшөөрөлтэй байх. 8. Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай инженерийг томилсон байх. 9. Тухайн инженер нь мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан байх./нотлох баримтыг хавсаргах/ 10. Инженерийн сургууль төгссөн, дипломны хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлэх. 11. Барааны жагсаалт ба барааны нийлүүлэлтийн хуваарийг ирүүлэх. 12. Техникийн тодорхойлолтыг хангаж буй нийцлийн хүснэгтийг ирүүлэх. 13. Баталгаат засвар 1 жил байна. Баталгаат засварын хугацаанд эвдрэл, үл тохирлыг нийлүүлэгчийн зардлаар засварлаж шинэчлэх тухай албан мэдэгдлийг ирүүлэх. 14. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. /Үүнийг албан ёсоор ирүүлэх/
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: [Улаанбаатар хот, ХУД-ын 21-р хороо Иргэний нисэхийн ерөнхий газар] Давхар болон өрөөний дугаар: [Худалдан авах ажиллагааны тасаг 1 давхар, 108 тоот] Огноо: [2020 оны 06 дугаар сарын 16-ны өдөр] Цаг: [10 цаг 00 минут]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: [Улаанбаатар хот, ХУД-ын 21-р хороо Иргэний нисэхийн ерөнхий газар] Давхар болон өрөөний дугаар: [Худалдан авах ажиллагааны тасаг 1 давхар, 108 тоот] Огноо: [2020 оны 06 дугаар сарын 16-ны өдөр] Цаг: [10 цаг 30 минут]</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дээрхи маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 2. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт 3. Нийгмийн даатгалын өр төлбөргүй талаарх цахим тодорхойлолт 4. Татварын албаны цахим тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар өр төлбөргүй байх/ 5. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Галын дохиоллын систем шинэчлэх /ИНЕГ-ын байр/ ИНЕГ/УЗ/ТББ/Б-46/20</p>

Дөрөв: **БАРАА НИЙЛҮҮЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА,
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

АГУУЛГА

1. Барааны нэр төрлийн жагсаалт болон нийлүүлэлтийн хуваарь
2. Холбогдох үйлчилгээний жагсаалт болон гүйцэтгэлийн хуваарь
3. Техникийн тодорхойлолтыг хавсралт хүснэгтээс үзнэ үү.

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

д/д	Материалын нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Болид С2000М/ Галын дохио удирдлагын гар/	Тэжээлийн хүчдэл: DC, 10.2...28.4 В LED дэлгэцтэй Холбогдох төхөөрөмжийн тоо: 127 Дэмжиж буй хэсгүүд: 511 Хянагчийн өөрийн хэрэглээ: хүчдэл 12 В 120мА, хүчдэл 24 В 65МА ихгүй Хаягжуулах бүсүүдийн тоо: 127 Санах ой: 8000 Мэдээлэл дамжуулах кабелин урт: 3000м дотор Ашиглалтын температурын хүрээ: -10...+55 °С Жин: 0.3 кг Хэмжээ: 140x114x25 мм IP30	1	ИНЕГ	30	45	
2	Сигнал 20П/Галын дохиоллын хүлээн авах станц/	Тэжээлийн хүчдэл: DC, 10.2...28.4 В Хяналтын LED гэрэлтэй байх. Ачаалалын нийт гүйдэл: 60МА ихгүй Хаягжуулах бүсүүдийн тоо, 20 Мэдээлэл дамжуулах кабелин урт: 1200м дотор Ашиглалтын температурын хүрээ: -30...+50 °С Жин: 0.4 кг Хэмжээ: 230x135x37 мм Ажиллгааны дундаж хугацаа: 10 жил	2	ИНЕГ	30	45	
3	ИП-212-45 /Утаа мэдрэгч/	Тэжээлийн хүчдэл: DC, 8...11 В Утаа мэдрэгчийн төрөл, хаягжуулдаггүй Мэдрэгчийн мэдрэмж: 0.05 ... 0.2 дБ / м Гэрлийн заалт: "Хүлээлгийн горим", "Гал" Хяналтын LED гэрэлтэй байх. Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл: 0.5 мА Ашиглалтын температурын хүрээ: -30...+55 °С Жин: 0.2 кг Хэмжээ диаметр, өндөр: 100x47 мм	60	ИНЕГ	30	45	
4	ИП-101-1А-А1 /Дулаан мэдрэгч/	Тэжээлийн хүчдэл: 8...11 В Мэдрэх температур: 54...65 ° С Дулаан мэдрэгчийн	2	ИНЕГ	30	45	

		<p>төрөл, хаягжуулдаггүй Мэдрэгчийн мэдрэмж: 0.05 ... 0.2 дБ / м Гэрлийн заалт, "Хүлээлгийн горим", "Гал" Хяналтын LED гэрэлтэй байх. Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл: 0.5 мА Ашиглалтын температурын хүрээ: 10...+76 °С Жин: 0.02 кг Хэмжээ диаметр, өндөр: Ф62х34 мм IP30</p>				
5	РИП 12В 3А /Тэжээлийн блок/	<p>Тэжээлийн хүчдэл: АС, 150...250 В Хяналтын LED гэрэлтэй байх. Хэрэглэний гүйдэл: 1.5 А Гаралтын хүчдэл: 26.6...27.8 В Гаралтын гүйдэл: 4...5 А Аккумулятор: 12 В 26...40 Ац 2 ширхэг Богино холболтын хамгаалалт байх. Ашиглалтын температурын хүрээ: -10...+40 °С Жин: 0.3 кг Хэмжээ: 450х400х210 мм IP30</p>	2	ИНЕГ	30	45
6	ИПР 513 /Гар мэдээлэгч/	<p>Тэжээлийн хүчдэл: 8...11 В Утаа мэдрэгчийн төрөл, хаягжуулдаг Гэрлийн заалт, "Хүлээлгийн горим", "Гал" Хяналтын LED гэрэлтэй байх. Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл: 0.5 МА Ашиглалтын температурын хүрээ: -30...+55 °С Жин: 0.15 кг Хэмжээ: 95х91х33 мм IP 20</p>	4	ИНЕГ	30	45
7	Маяк-/Дуут дохио/	<p>Тэжээлийн хүчдэл: 12 В Дууны даралтын түвшин: 105 дБ Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл: 0.75 мА Ашиглалтын температурын хүрээ: -30...+55 °С Жин: 0.06 кг Хэмжээ: 100х80х42 мм IP 55</p>	4	ИНЕГ	30	45
8	С2000-БКИ /Галын дохиоллын хяналтын блок/	<p>Хяналтын LED гэрэлтэй, 60 Тэжээлийн хүчдэл: DC, 10.2...28.4 В Хэрэглээний гүйдэл: хэвийн үед 50 мА, түгшүүрийн үед 200 мА Ашиглалтын температурын хүрээ, -30...+50 °С Жин, 0.6 кг Хэмжээ, 340х170х27.5 мм IP 20</p>	1	ИНЕГ	30	45

9	Баттерей	12V 7AH	2	ИНЕГ	30	45	
10	Утас кабель	Галд тэсвэртэй бүрээстэй FRLS	1000	ИНЕГ	30	45	
11	Кабель далдлагч		800	ИНЕГ	30	45	
12	Галын хор	СЕ Евро стандарт, ABC-4кг, Бүх төрлийн гал унтраах хүчин чадал бүхий, аваарын клапан, дахин цэнэглэх боломжтой, хадгалах нөхцөл - 30+60С,	35	ИНЕГ	30	45	
13	Автомат галын хор	СЕ Евро стандарт, ABC-6кг автомат галын хор, 68С мэдэрч автоматаар ажиллана. Бүх төрлийн гал унтраах хүчин чадал бүхий аваарын клапан, дахин цэнэглэх боломжтой, хадгалах нөхцөл -30+60С,	2	ИНЕГ	30	45	
14	Оффис ком	СЕ евро стандарт шаардлага хангасан, СЕ Евро 6кг галын хор, галын хөнжил, жижиг хүрз, жижиг сүх, хадаасны лоом, Анхны тусламж сэт 2ш, аваарын гэрэл	2	ИНЕГ	30	45	
15	Аваарын гэрэл	тог тасрахаар автоматаар асаж орчныг гэрэлтүүлнэ. LED, нөөц цэнэгээр 30-60минут асна.	5	ИНЕГ	30	45	
16	EXIT гэрэл	Тог тасрахаар автоматаар асаж орчныг гэрэлтүүлнэ. Нөөц цэнэгээр 30- 60минут асна.	5	ИНЕГ	30	45	

**ГАЛЫН ДОХИОЛЛЫН СИСТЕМИЙН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолтод галын дохиоллын системийг шинэчлэх /ИНЕГ-ын байр/-д шаардлагатай барааны нэр, техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

2. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.1 Нийлүүлэгдэх барааны техникийн үзүүлэлтүүд нь доорх шаардлагыг бүрэн хангасан байна.

д/д	Материалын нэр	Техникийн үзүүлэлт	Тоо ширхэг
1	Болид С2000М/ Галын дохио удирдлагын гар/	Тэжээлийн хүчдэл: DC, 10.2-28.4В LED дэлгэцтэй Холбогдох төхөөрөмжийн тоо: 127 Дэмжиж буй хэсгүүд: 511 Хянагчийн өөрийн хэрэглээ: хүчдэл 12 В 120mA, хүчдэл 24 В 65mA ихгүй Хаягжуулах бүсүүдийн тоо: 127 Санах ой: 8000 Мэдээлэл дамжуулах кабелин урт: 3000м дотор Ашиглалтын температурын хүрээ: -10...+55 °С Жин: 0.3 кг Хэмжээ: 140x114x25 мм IP30	1
2	Сигнал 20П/Галын дохиоллын хүлээн авах станц/	Тэжээлийн хүчдэл: DC, 10.2-28.4В Хяналтын LED гэрэлтэй байх. Ачаалалын нийт гүйдэл: 60mA ихгүй Хаягжуулах бүсүүдийн тоо, 20 Мэдээлэл дамжуулах кабелин урт: 1200м дотор Ашиглалтын температурын хүрээ: -30...+50 °С Жин: 0.4 кг Хэмжээ: 230x135x37 мм Ажиллгааны дундаж хугацаа: 10 жил	2
3	ИП-212-45 /Утаа мэдрэгч/	Тэжээлийн хүчдэл: DC, 8-11 В Утаа мэдрэгчийн төрөл, хаягжуулдаггүй Мэдрэгчийн мэдрэмж: 0.05 ... 0.2 дБ / м Гэрлийн заалт: "Хүлээлгийн горим", "Гал" Хяналтын LED гэрэлтэй байх. Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл: 0.5 mA Ашиглалтын температурын хүрээ: -30...+55 °С Жин: 0.2 кг Хэмжээ диаметр, өндөр: 100x47 мм	60
4	ИП-101-1А-А1 /Дулаан мэдрэгч/	Тэжээлийн хүчдэл: 8-11В Мэдрэх температур: +54...+65 °С Дулаан мэдрэгчийн төрөл, хаягжуулдаггүй Мэдрэгчийн мэдрэмж: 0.05-0.2 дБ/м Гэрлийн заалт, "Хүлээлгийн горим", "Гал" Хяналтын LED гэрэлтэй байх. Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл: 0.5 mA Ашиглалтын температурын хүрээ: -10...+76 °С Жин: 0.02 кг Хэмжээ диаметр, өндөр: Ф62x34 мм IP30	2
5	РИП 12В 3А /Тэжээлийн блок/	Тэжээлийн хүчдэл: AC, 150-250В Хяналтын LED гэрэлтэй байх. Хэрэглэний гүйдэл: 1.5 mA	2

		Гаралтын хүчдэл: 26.6-27.8В Гаралтын гүйдэл: 4-5mA Аккумулятор: 12-26В...40 mA/цаг Богино холболтын хамгаалалт байх. Ашиглалтын температурын хүрээ: -10...+40 °С Жин: 0.3 кг Хэмжээ: 450x400x210мм IP30	
6	ИПР 513 /Гар мэдээлэгч/	Тэжээлийн хүчдэл: 8-11В Утаа мэдрэгчийн төрөл, хаягжуулдаг Гэрлийн заалт, "Хүлээлгийн горим", "Гал" Хяналтын LED гэрэлтэй байх. Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл: 0.5mA Ашиглалтын температурын хүрээ: -30...+55 °С Жин: 0.15 кг Хэмжээ: 95x91x33 мм IP 20	4
7	Маяк-/Дуут дохио/	Тэжээлийн хүчдэл: 12В Дууны даралтын түвшин: 105 дБ/м Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл: 0.75 mA Ашиглалтын температурын хүрээ: -30...+55 °С Жин: 0.06 кг Хэмжээ: 100x80x42 мм IP 55	4
8	С2000-БКИ /Галын дохиоллын хяналтын блок/	Хяналтын LED гэрэл: 60 mA Тэжээлийн хүчдэл: DC, 10.2-28.4В Хэрэглээний гүйдэл: хэвийн үед 50 mA, түгшүүрийн үед 200 mA Ашиглалтын температурын хүрээ, -30...+50 °С Жин: 0.6 кг Хэмжээ: 340x170x27.5 мм IP 20	1
9	Баттерей	12V 7AH	2
10	Утас кабель	Галд тэсвэртэй бүрээстэй FRLS	1000метр
11	Кабель далдлагч	Зориулалтын	800 метр
12	Галын хор	СЕ Евро стандарт, ABC-4кг, Бүх төрлийн гал унтраах хүчин чадал бүхий, аваарын клапан, дахин цэнэглэх боломжтой, хадгалах нөхцөл -30....+60С,	35
13	Автомат галын хор	СЕ Евро стандарт, ABC-6кг автомат галын хор, 68С мэдэрч автоматаар ажиллана. Бүх төрлийн гал унтраах хүчин чадал бүхий аваарын клапан, дахин цэнэглэх боломжтой, хадгалах нөхцөл -30....+60С,	2
14	Оффис ком	СЕ евро стандарт шаардлага хангасан, СЕ Евро 6кг галын хор, галын хөнжил, жижиг хүрз, жижиг сүх, хадаасны лоом, Анхны тусламж сэт 2ш, аваарын гэрэл	2 ком
15	Аваарын гэрэл	Тог тасрахаар автоматаар асаж орчныг гэрэлтүүлнэ. LED гэрэлтэй байх, нөөц цэнэгээр 30-60минут асна.	5
16	EXIT гэрэл	Тог тасрахаар автоматаар асаж орчныг гэрэлтүүлнэ. Нөөц цэнэгээр 30-60 минут асна.	5

3. ХҮЛЭЭН АВАХ

3.1 Нийлүүлэгч тал нь техникийн үзүүлэлтийг бүрэн хангасан материалыг үйлдвэрлэгчийн шалгалт тохируулга хийсэн баримт, хэмжилт тохируулгын гэрчилгээний хамт нийлүүлж, суурилуулах ажлыг гүйцэтгэнэ.

3.2 ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлт, суурилуулсан байдал, иж бүрдлийг шалгаж, ажил хүлээн авах актыг үйлдсэнээр ажлыг хүлээн авсанд тооцно.

3.3 Баталгаат засварын хугацаа ажил хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар байна.

3.4 Ажлын талбай: Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо Иргэний нисэхийн ерөнхий газар

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [30] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Иргэний нисэхийн ерөнхий газраас ажлын комисс томилон барааг хүлээж авна |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааны гарал үүслийн гэрчилгээ.3) Техникийн тодорхойлолтыг хангаж буй байдал4) Барааг суурилуулсны дараа техникийн бүрэн бүтэн ажиллаж байгаа эсэхийг шалгасан талаарх ажил хүлээн авах комиссын акт <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 3.1. Баталгаат засварын хугацаанд эвдрэл, үл тохирлыг нийлүүлэгчийн зардлаар засварлаж шинэчилнэ.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none">1. Ирсэн барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлбөрийг төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 5.1. Алданги оногдуулах хувь: [Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%]
5.2. Алдангийн нийт дүн: [Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%] |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]